



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 226


Улаанбаатар хот

### Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 21/726/ТЗ тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт"-ыг нэгдүгээр, "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б.МӨНХБААТАР


Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 10 дугаар сарын 12 ны өдрийн  
14 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт  
006



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ  
АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Мандал мөнх эрчим" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 6.3, 6.4	5
2	"Ботгонхөөвөр" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 3.3, 3.4, 6.1, 6.2, 6.3, 6.4, 7.1	5
3	"Өнө гэрэгэ констракшн" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 7.1	5

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн  
146 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Ай Эм Кэй" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-3.7	5